



**ЗАВХАН АЙМГИЙН
ЯРУУ СУМЫН ЗАСАГ ДАРГА**

81130 Чандмань, Яруу сум
И-мэйл: yaruu.gov24@yahoo.com

2025. 08. 06 № 1/19
танай _____-ны № _____ т

**УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМД**

Хяналтын журмаар гомдол гаргах

тухай

Завхан аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 61 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 74 дүгээр магадлалыг тус тус эс зөвшөөрч, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.2-д заасныг үндэслэн хяналтын журмаар гомдол гаргаж байна.

Нэхэмжлэгч Цагаан өвөлжөө ХХК-аас 2023, 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг батлахгүй байгаа Яруу сумын Засаг даргын эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, уг төлөвлөгөөг батлахыг даалгуулах, Яруу сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн "Орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай" 13 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах" шаарддлага бүхий нэхэмжлэл гаргасан.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д "Энэ хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино" 3 дугаар зүйлийн 3.1.3-д "нэхэмжлэл" гэж хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд тусгайлан заасан бол захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдлийг" хэлнэ гэж тус тус зааснаар шүүх нэхэмжлэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж, зөрчигдсөн эрхийг сэргээхээр заажээ.

Харин нэхэмжлэгчийн тухайд түүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөөгүй байхад анхан болон давж заалдах шатны шүүхээс нэхэмжлэлийг хангаж, шийдвэрлэсэн нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий болоогүй байна.

Яруу сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн "Орон нутгийн тусгай хэрэгцээнд авах" тухай 13 дугаар тогтоолоор Хэц-Улаан, Зүйл багийн нутагт орших Цахир уул орчмын 3252, 7464 га газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, уг газрыг Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 10/339 дүгээр албан бичгээр Уул уурхайн кадастрын хэлтсийн бүртгэлийн системд бүртгэснийг мэдэгдсэн.

Гэтэл нэхэмжлэгч "Цагаан өвөлжөө" ХХК-д Завхан аймгийн Алдархаан болон Яруу сумын нутагт байрлах Цахир уул нэртэй ашигт малтмалын хайгуулын XV-022521 дугаартай тусгай зөвшөөрлийг Ашигт малтмал газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 289 дүгээр шийдвэрээр олгосон нь Яруу сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг зөрчсөн.

Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13-д "тусгай хэрэгцээний газар" гэж Газрын тухай хуулийн 17, 18, 20 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий байгууллагаас улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авч ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон газрыг" ойлгохоор заажээ.

Засгийн газрын 2018 оны 243 дугаар тогтоолоор хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг солбилцлоор баталсан, тухайн талбайд багтсан Яруу сумын тодорхой газрыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 13 дугаар тогтоолоор орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, энэ талаараа эрх бүхий захиргааны байгууллага болох Ашигт малтмал газрын тосны газарт мэдэгдсний дагуу бүртгэлийн сандаа бүртгэсэн боловч захиргааны байгууллага Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.26-д зааснаар сонгон шалгаруулалт явуулах талбай нь орон нутгийн тусгай хэрэгцээний талбайтай давхцсан байхад уг хэсгийг хасалгүйгээр 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр тусгай зөвшөөрөл олгохоор сонгон шалгаруулалт зарлаж, тусгай зөвшөөрөл олгосон нь хууль бус болжээ.

Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгчид ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хориглосон буюу орон нутгийн тусгай хэрэгцээний газартай давхцуулан тусгай зөвшөөрөл олгосныг хуулийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл гэж үзэх үндэслэлгүй юм.

Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-д "Эс үйлдэхүй гэж иргэн, хуулийн этгээдээс эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хэрэгжүүлэх, хамгаалуулахаар гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх үүргээ захиргааны байгууллага хуульд заасан хугацаанд биелүүлээгүй, эсхүл шийдвэрлэхгүй орхигдуулсныг ойлгоно" гэжээ.

Хариуцагч Засаг даргаас орон нутгийн тусгай хэрэгцээний газартай давхцсан талбайд нэхэмжлэгчээс ирүүлсэн 2023, 2024 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг батлах нь хуульд нийцэхгүй учир 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 1/128, 2024 онд мөн татгалзсан хариуг албан бичгээр өгсөн нь Захиргааны ерөнхий хууль заасан эс үйлдэхүй биш байхад анхан болон давж заалдах шатны шүүх буруу дүгнэж, хариуцагчийг эс үйлдэхүй гаргасан гэж үзснийг хүлээн зөвшөөрөхгүй.

Мөн нэхэмжлэгч нь Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1-д "тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах" гэж зааснаар эхлээд Засаг даргатай зөвшилцөх ёстой байхад шууд боловсруулсан төлөвлөгөөг батлуулахаар ирүүлсэнд хариуцагчийг буруутгаж, байгаль орчны төлөвлөгөөг батлах ёстой гэж анхан болон давж заалдах шатны шүүхээс хуулийг буруу тайлбарласан гэж үзэж байна.

Үүнээс гадна нэхэмжлэгчид 2023 оны байгаль орчны төлөвлөгөөг батлах боломжгүй талаар 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 1/128 дугаар албан бичгээр хариу өгсний дагуу нэхэмжлэгч нь Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-д "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана" гэж заасан 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргаагүй буюу 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр гомдол гаргасныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааг хуулийн дагуу хийсэн гэж үзэхгүй.


Гэтэл анхан шатны шүүхээс энэ талаар дүгнэлт хийхдээ нэхэмжлэгчийг хөөн хэлэлцэх хугацаа хэтрүүлсэн гэж үзэхгүй хэмээн буруу тайлбарлан хэрэглэсэн нь

захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.3-д заасантай нийцэхгүй байна.

Иймд нэхэмжлэгчийн 2023 оны байгаль орчны төлөвлөгөөг батлахгүй байгаа эс үйлдэхүйтэй холбоотой нэхэмжлэлийн шаардлагыг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.3-д заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэх ёстой байхад анхан шатны шүүхээс хүлээн авч шийдвэрлэсэн, уг алдааг давж заалдах шатны шүүхээс залруулаагүй нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил болно.

Дээр дурдснаар анхан болон давж заалдах шатны шүүх нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ноцтой зөрчсөн нь тогтоогдож байх тул шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгнө үү.

ЗАСАГ ДАРГА



Б. ГАНЗОРИГ